



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 07 сарын 27 өдөр

Дугаар A/63

Улаанбаатар хот

“Тал нутгийн Монгол” олон улсын марафон гүйлтийн тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 01/19 дүгээр тогтоолоор батлагдсан Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1-49, Нийслэлийн Засаг даргын 2018 оны A/674 тоот захирамж, тус газрын дүрмийн 2.5.3, 3.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсыг олон улсад сурталчлах, тусгай сонирхлын аяллыг хөгжүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалах, нийслэлийн иргэдийг спортоор хичээллэх боломжийг бүрдүүлэх зорилгоор “Тал нутгийн Монгол” олон улсын марафон гүйлтийн тэмцээнийг 2018 оны 08 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсугай.

2. Олон улсын марафон гүйлтийн тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсөв болох 9 870 000 /Есөн сая найман зуун далан мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д зөвшөөрсүгэй.

4. Арга хэмжээний үеэр хамтран ажиллах, гэрээ байгуулах байгууллагуудыг судалж, 2018 оны 07 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө танилцуулахыг Ажлын хэсэг /В.Батчимэг/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАТСҮХ



1150500207



Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 07
сарын 27 өдрийн А/63 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СБТ 8936 1118263502

“Тал нутгийн Монгол” олон улсын марафон
гүйлтийн тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг
үзүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ахлагч	В.Батчимэг	/Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч/
Гишүүд	Ш.Ундармаа	/Соёлын аялал жуулчлал, салбарын хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн/
	Н.Алтанзаяа	/Хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн/
	Б.Ишдорж	/Бүтээгдэхүүний хөгжил, дотоодын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн/
Нарийн бичгийн дарга	Б.Ербахыт	/Статистик, сургалт, судалгаа хариуцсан мэргэжилтэн/

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын дартын 2018 оны 07
сарын 27 өдрийн А/Б3 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

5234325 СБТ 48936 1116263502

“Тал нутгийн Монгол” олон улсын марафон
гүйлтийн тэмцээнийг зохион байгуулах
төсвийн задаргаа

2018 оны 07 дугаар сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын төрөл		Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Тайзны түрээсийн төлбөр /5x4 хэмжээтэй/		1	2 090 000	2 090 000
2	Асар, майханы түрээсийн төлбөр /4x4 м хэмжээтэй, 1 өдөр/		10	120 000	1 200 000
3	Автобус түрээслэх		5	280 000	1 400 000
4	Цэвэр ус /500 гр/		3500	400	1 200 000
5	Медаль		200	8 000	1 600 000
6	Зөөврийн био 00 түрээслэх төлбөр		4	270 000	1 080 000
7	21 км зайн эхний гурван байрны шагнал	1-р байр /эр,эм/	2	300 000	600 000
		2-р байр /эр,эм/	2	200 000	400 000
		3-р байр /эр,эм/	2	150 000	300 000
НИЙТ					9 870 000